



ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН СЭДЭВ: СЭЛЭНГЭ АЙМГИЙН ОРХОНТУУЛ
СУМЫН 2024 ОН, 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ДА-2025/03/ҮА-ТТЗ

Сүхбаатар сум 2025 он	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газар Цахим хуудас: selenge@sankhuuaudit.se.gov.mn Дотоод аудитор: Г.Дорждэрэм Холбоо барих утас: 7036-8811 Цахим хаяг: Dorjderem@sankhuuaudit.se.gov.mn
--------------------------	--

**АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, СТАНДАРТЫН
ТАЛААРХ МЭДЭГДЭЛ**

<p>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:</p>	<p>Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэг, “Дүрэм батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Дотоод аудитын дүрэм”, Дотоод аудитын хорооны 2025 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан 2025 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.</p>
<p>Аудитын зорилт:</p>	<p>Орхонтуул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой</p>
<p>Аудитын хамарсан хүрээ:</p>	<p>Орхонтуул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 он, 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн баримт материалыг хамруулав.</p>
<p>Аудитын арга зүй:</p>	<p>Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, харьцуулалт, түүвэрлэлт зэрэг судалгааны арга зүйг ашиглан аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.</p>
<p>Аудитын шалгуур, үзүүлэлт:</p>	<p>Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Төрийн хэмнэлтийн тухай хууль <ul style="list-style-type: none"> • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль • Авлигын эсрэг хууль • Төсвийн тухай хууль • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль • Хөдөлмөрийн тухай хууль • Төрийн хэмнэлтийн тухай хууль • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль • Татварын ерөнхий хууль • Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам • Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам • Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам • УСННББОУС болон бусад стандартууд • Бусад хууль, эрх зүйн актууд • Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг • Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам

НЭГ. ТАНИЛЦУУЛГА

Сэлэнгэ аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын 2025 оны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг дарга бөгөөд Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн 2025 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн ДА-2025/03/ҮА-ТТЗ дугаар удирдамжийн хүрээнд Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд дотоод аудитыг хийж гүйцэтгэлээ.

Дотоод аудитыг Засгийн газрын 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийг тус тус үндэслэн санхүүгийн хяналт шалгалт, эрх зүйн нийцлийн чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ба 2024 он, 2025 оны эхний хагас жилийн үйл явцыг хамруулан, дахин тооцоолох, тулган шалгах хяналтын горимыг ашиглах, холбогдох ажилтнуудтай ярилцах, дотоод хяналтын орчныг судлах, үнэлэх, ажил гүйлгээг батлах, хянах, бүртгэх, тайлагнах процессын эрсдэлийг үнэлэх, мөрдвөл зохих хууль тогтоомжийн зүйл, хэсэг, заалтын хэрэгжилтийн байдлыг бодитоор илэрхийлж тогтоох, зорилгод хүрсэн түвшин, хүлээн зөвшөөрөгдсөн байдал, практикт нийцэж байгаа байдлыг шалгуур үзүүлэлтээр тодорхойлж ажиллав.

ХОЁР. АУДИТЫН ЗОРИЛГО, ЦАР ХҮРЭЭ

2.1 Аудитын зорилго:

Орхонтуул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын үйл явцуудын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, тус байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилготой.

2.2 Аудитын хамрах хүрээ, хязгаарлалт

Орхонтуул сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн удирдлага зохион байгуулалтын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцыг үнэлэх;

Аудитаар тус газрын 2024 он, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагааг хамруулна. Үүнд:

- Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлагын үйл явцыг үнэлэх;
- Төсвийн орлогын бүрдүүлэлт, санхүүжилт, хуваарилалт, үр дүн
- Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр дүн
- Орон нутгийн хөгжлийн сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн
- Хоршоог хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт үр дүн
- Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн хэрэгжилт
- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын үр нөлөө
- Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын арилгах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байдал

Дотоод аудитын хамрах хүрээний хязгаарлалт:

Дотоод аудит хийх хугацаатай давхцан Төрийн аудитын газраас “Орон нутгийн төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”

сэдэвт аудитын үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаатай холбогдуулан тус ТТЗ-ийн 2024 оны хөрөнгө оруулалттай холбоотой баримт бичгүүдийг Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

Иймд ТТЗ-ын 2024 оны хөрөнгө оруулалтын баримтуудыг бүртгэл мэдээлэлтэй тулган баталгаажуулах ажиллагаа хийгдээгүй болно.

Аудитын явцад хязгаарлалт тогтоохгүй, шинж чанарын үүднээс цааш нь нарийвчилсан горим сорил хэрэгжүүлж болно.

2.3 Аудитын арга, аргачлал

Дотоод аудитын мэргэжлийн практикийн Олон улсын стандарт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Монгол улсын сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар батлагдсан “Улсын салбарын дотоод аудитын аргачлал”-ын дагуу үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэн албан тушаалтнаас асуулга тодруулга авах, нотлох зүйлсийг нягтлах, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх горимуудыг ашиглав.

2.4. Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитын зорилттой холбоотой дараах хууль, журам, дүрэм, зааврыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам
- Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам
- УСНББОУС болон бусад стандартууд
- Төрийн сангийн төлбөр тооцооны журам
- Бусад хууль, эрх зүйн актууд

2.5 Аудитын хугацаа, бүрэлдэхүүн

Дотоод аудитыг 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дарга СХШАУБ Т.Одсүрэн ахалж, дотоод аудитор Г.Дорждэрэм гүйцэтгэв.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН САЙН ТУРШЛАГА, ЭРСДЛИЙН УДИРДЛАГА, ДОТООД ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

3.1 Байгууллагын сайн туршлага

Орхонтуул сум нь улсын болон орон нутгийн чанартай авто замуудтай шороон замаар холбогддог. Монгол Улсын Засгийн газраас баталсан Бүсчилсэн хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсаны дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2025-2027 онд Төв аймгийн Цээл сумаас Орхонтуул, Орхонтуул сумаас Баруунбүрэн сумтай холбох хатуу хучилттай авто замын төсөл хэрэгжүүлэхээр эхлүүлсэн байна. Энэхүү авто замын нийт урт нь 62.56 км бөгөөд төсөвт өртөг 118,449.5 сая төгрөг байна.

Түүнчлэн, 2025 оны улсын төсөвт Орхон голын бетон гүүрийн барилгын ажлыг дуусгах 5,643.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ тусгагдсан нь тус чиглэлийн авто замын бүтээн байгуулалтыг иж бүрэн, үр ашигтай хэрэгжүүлэх чухал арга хэмжээ болж байна.

Сумын удирдлагын баг болоод төрийн албан хаагч нар тогтвор суурьшилтай ажилладаг тул төрийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад ямар нэгэн саад бэрхшээл тулгардаггүй болно. Төрийн бодлогын хэрэгжилтийг орон нутагтаа үр дүнтэйгээр хэрэгжүүлж, байгаль орчныг хамгаалах, нийгмийн хариуцлага, иргэдийн оролцоог хангах чиглэлээр дараах онцлог ажлуудыг хэрэгжүүлсэн байна.

1. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан Онцгой байдлын байгууллага, төр төсвийн 11 байгууллагатай хамтран "Ой хээрийн түймрээс сэргэмжлэе" нөлөөллийн ажлыг цахим болон биечлэн хэлбэрээр зохион байгуулсан байна.

2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилт амжилттай Сумын хэмжээнд 2000 ширхэг мод тарьж, "Өрх бүр нэг мод" хөтөлбөрөөр 15 өрхөд суулгац өгч, "Амьдралын төгөл", бичил цэцэрлэг зэрэг шинэ ногоон байгууламж бий болгосон.

3. Татмын ойг нөхөн сэргээх ажлыг эхлүүлсэн Орхон голын сав дагуу 30 га бургасжуулах, 10 га мод тарих талбайн кадастр хийж ИТХ-д өргөн барьсан нь байгаль орчныг хамгаалах тогтвортой шийдэл болсон байна.

4. Ховор амьтан хамгаалах – Аргалын сүргийг судалсан Аймгийн Байгаль орчны газар болон анчдын холбоотой хамтран Аргалын сүргийн шилжилт хөдөлгөөн, тоо толгойг тогтоох ажлыг Хонгор овоо орчимд зохион байгуулсан.

3.2 Засаглалын талаар

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын удирдлагын багт ИТХ-ын даргаар Д.Батзаяа Засаг даргаар Т.Болдбаатар, Рашаант тосгоны захирагчаар Б.Отгонбаяр нар 2024 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр томилогдсон байна. Засаг даргын 2025-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 2024 онд 87,9 хувь, аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээний биелэлт 2023 онд 71,2 хувь, 2024 онд 73,1 хувь, Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 2023 онд 90,3 хувь, 2024 онд 97,8 хувь, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт 2023 онд 74,5, 2024 онд 91,1 хувь, "Аялал жуулчлал-ногоон хөгжлийг дэмжих жил"-ийн ажлын төлөвлөгөөний хэрэгжилт 2024 онд 74,3 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Засаглах удирдлага, гүйцэтгэх удирдлагын хооронд эрсдэл, хяналтын талаар мэдээлэл солилцдог.

Сумын Засаг дарга Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын бодлого шийдвэр, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийн зорилтын хэрэгжилтийг зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавин, иргэдэд төрийн үйлчилгээг ил тод, түргэн шуурхай, нээлттэй, тэгш хүртээмжтэй хүргэхэд гол ажлуудыг шийдвэрлэсэн байна.

Аймгийн Хяналт-шинжилгээ үнэлгээний хэлтсээс Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын хэрэгжилтийг ханган хагас бүтэн жилээр бүх шатны захиргааны байгууллага нь өөрийн хариуцсан асуудлын хүрээнд хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байдалд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

3.3 Байгууллагын эрсдэлийн удирдлагын тогтолцоо

ТТЗ-ын засаглалын тогтолцооны нэг бүрэлдэхүүн болох эрсдэлийн удирдлагын чиглэлээр удирдлага болон ажилтан албан хаагчид эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдах талаар мэдлэг, чадвар дутмаг байна. Эрсдэлийн мэдээллийг цуглуулах, дүн шинжилгээ хийх, шийдвэр гаргалтад ашиглах механизм бүрдээгүй эрсдэлээ бүртгэж үнэлж дүгнэх, хариу арга хэмжээг авахгүй байгаа нь эрсдэлийн удирдлагын тогтолцоо төлөвшөөгүйг илэрхийлж байна.

Иймд эрсдэлийн удирдлагын хэрэгжилтийг хангахтай холбогдуулан дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- *ТТЗ-ын үйл ажиллагаатай холбогдуулан эрсдэлийг /хүний нөөцийн, үйл ажиллагааны, стратегийн, санхүүгийн, нийгэм, засаглалын, мэдээлэл технологийн, зах зээлийн, байгаль орчин, бусад гэх мэт/ ангилан бүртгэх*
- *Эрсдэлийн түвшингээр нь бага, дунд, их гэж ангилах замаар эрсдэлийн удирдлагын хариу арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан эрсдэлийг удирдах нөхцөлийг бүрдүүлэн үр дүнг тооцож ажиллах*
- *Эрсдэлийн удирдлагын тогтолцоог төлөвшүүлэх цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг Эрсдэлийн удирдлагын менежментийн ISO 31000 стандарт, MNS ISO 31010:2016 Эрсдэлийн үнэлгээний арга, MNS ISO 31000:2020 Эрсдэлийн менежментийн удирдамжийг үе шаттайгаар нэвтрүүлэх нь зүйтэй.*

3.4 Байгууллагын дотоод хяналтын тогтолцоо

Тус ТТЗ нь дотоод хяналтыг зохион байгуулах төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажилласан байна. Энэ нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ыг 1.4 дэх заалттай нийцээгүй бөгөөд тус журмын дагуу гүйцэтгэх дотоод хяналтыг зохих удирдамж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтыг гүйцэтгэж, дүнг тайлагнах үйл явц хангалтгүй байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчид шууд харьяалагдах дотоод хяналт

хариуцсан ажилтны орон тоог одоог батлуулаагүй гүйцэтгэх чиг үүрэг тодорхойгүй, дотоод хяналт шалгалт зохион байгуулах журмыг боловсруулж батлуулаагүйгээс дотоод хяналт сул байна.

Дотоод хяналтыг удирдамж, төлөвлөгөөг зөвхөн харьяа нэгжүүд өөрсдийн чиг үүргийн дагуу хийж байгаа нь нэгдсэн удирдлагын тогтолцоо бүрдээгүйг илэрхийлж байна.

ГУРАВ. АУДИТЫН ҮР ДҮН

<u>Илэрсэн асуудал 1</u>	Малын тоо толгойн албан татварыг статистикийн жилийн эцсийн мал тооллогын дүнд үндэслэн бодитоор ногдуулаагүй 2023 онд 29,959.0 мянган төгрөгөөр дутуу, 2024 онд 24,627.0 мянган төгрөгөөр илүү ногдуулсан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: Татварын хууль тогтоомжийн дагуу малчин өрх бүрийн малын тоо толгойд үндэслэн албан татвар ногдуулах ёстой. Гэтэл малын тоо толгойн албан татварын 2023, 2024 онуудын жилийн эцсийн тооллогын мэдээллийг үндэслээгүй 2023 онд 29,959.0 мянган төгрөг, 2024 онд 24,627.0 мянган төгрөг буюу нийт 54,586.0 мянган төгрөгөөр зөрүүтэй ногдуулсан байна. Малын тоо толгойн албан татварыг нь малын тоо толгойд үндэслэн төлөвлөөгүйгээс орлого бүрдүүлэлт тасарч, орон нутгийн төсөвт сөргөөр нөлөөлж байна.	
Байх ёстой шаардлага /шалгуур/: Малын тоо толгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох: 5.2-д "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно."	
Асуудлын үндсэн шалтгаан: Малын тоо толгой албан татварын тухай хуулийн хэрэгжүүлээгүй, татварын байцаагч жирэмсэн амаржсаны амралттай байснаас шалтгаалсан байна.	
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Татварын орлого тасалдах, улмаар орон нутгийн төсвийн орлого буурах, төсвийн хөрөнгийг зохистой хуваарилах, зарцуулахад хүндрэл үүсэх.	
Шийдвэр: 2026 оны төсвийн төсөлд малын тоо толгойн албан татварыг жилийн эцсийн бодит тооллогын дүн, тоо баримтад үндэслэн ногдуулах албан шаардлагыг хүргүүлэх	

<u>Илэрсэн асуудал 2</u>	Сумын Засаг дарга нь Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах болон хайгуулын зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд тавих хянах, гэрээний хэрэгжилтийг үнэлэх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хүлээн авч батлах, хэрэгжилтийн явцад хяналт тавих, мэдээллийг төрийн захиргааны холбогдох байгууллагуудад хүргүүлэх эрх, үүргээ огт хэрэгжүүлээгүй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: ТТЗ нь тус суманд үйл ажиллагаа явуулахаар түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах болон хайгуулын тусгай зөвшөөрөл авсан нийт 33 аж ахуйн нэгж байгууллагын судалгаа,	

мэдээлэл байхгүй, түүнчлэн гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээ байгуулсан тухай мэдээллийг төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллаагүй нь холбогдох хууль тогтоомжийн заалтыг зөрчсөн байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Ашигт малтмалын тухай хуулийн 12.2.Ашигт малтмалын асуудлаар сумын Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ,

12.2.1.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд хяналт тавих,

12.2.4.бичил уурхайгаар ашигт малтмал олборлох гэрээний хэрэгжилтийг хангуулах, гэрээ байгуулсан тухай мэдээллийг төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх, 12.2.5.ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянах, 38 дугаар зүйлийн 38.2.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 38.1.3, 38.1.6-д заасан төлөвлөгөө, түүний өөрчлөлтийг хүлээн авснаасаа хойш 10 хоногийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.Сум, дүүргийн Засаг дарга энэ хуулийн 27.1.1, 27.1.5-д заасан төлөвлөгөө, түүний өөрчлөлтийг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор хянан баталж тусгай зөвшөөрөл эзэмшигчид хүргүүлнэ.

Асуудлын үндсэн шалтгаан:

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хянан батлах, хэрэгжилтэд хяналт тавих тогтолцоо, хариуцлага, гүйцэтгэлийн хяналт сул байна

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Байгаль орчинд сөрөг нөлөө үүсэх эрсдэл өндөрсөх, нөхөн сэргээлт хийгдэхгүй байх, ашигт малтмалын үйл ажиллагаанд **төрийн хяналт сулрах**, хууль зөрчих эрсдэл нэмэгдэх

Шийдвэр:

Цаашид тус суманд үйл ажиллагаа явуулж буй түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах болон хайгуулын тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг хянах, гэрээний хэрэгжилтийг үнэлэх, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хүлээн авч батлах, хэрэгжилтийн явцад хяналт тавих, мэдээллийг төрийн захиргааны холбогдох байгууллагуудад хүргүүлэх **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 3</u>	Сумын ОНХС-ын хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжүүлэх 453,915.0 мянган төгрөгийн 5 төсөл арга хэмжээний зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгүйгээр батлуулсан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал:	2025 онд орон нутгийн хөгжлийн сан болон малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр нийт 548,915.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээнүүдийг зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийлгүйгээр баталсан байна. Үүнд: <ul style="list-style-type: none">• Рашаант тосгонд төрийн албан хаагчдын байр худалдан авахад 140,000.0 мянган төгрөг,• Хонхор болон Дөхөм хороололд гудамжны гэрэлтүүлэг нэмэхэд 30,000.0 мянган төгрөг,• Бор толгойн хороололд ухаалаг худаг шинээр гаргахад 40,000.0 мянган төгрөг,• Төрийн албан хаагчдын байр худалдан авахад дахин 140,000.0 мянган

<ul style="list-style-type: none"> • Үүрэн телефоны сүлжээтэй болоход 103,915.0 мянган төгрөг тус тус төсөвлөсөн байна. <p>Энэ нь хөрөнгө оруулалтын үр өгөөж, гүйцэтгэлийн чанарт сөргөөр нөлөөлөх нөхцөл бүрдүүлээд зогсохгүй, холбогдох хууль тогтоомжийн заалтыг зөрчиж байна.</p>
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/: Төсвийн тухай хуулийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Улсын болон орон нутгийн төсөв, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний жагсаалтад дараах зүйлсийг тусгахыг хориглоно: 13.3.3: “Техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв нь батлагдаагүй, газрын зөвшөөрөл олгогдоогүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ”</p>
<p>Асуудлын үндсэн шалтгаан: Төсөл, арга хэмжээний зураг, төсвийг төсөв батлагдсаны дараа хийлгэснээс худалдан авах ажиллагаа оройтсон</p>
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Энэ нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, гүйцэтгэлийн чанарт сөргөөр нөлөөлөх, хяналт, шалгалтын явцад зөрчил гарах нөхцөлийг бүрдүүлсэн байна.</p>
<p>Шийдвэр: 2026 онд шинээр хэрэгжүүлэх барилга байгууламж, их засварын төсөл, арга хэмжээний зураг, төсөв, үнийн судалгааг урьдчилан хийж төсөвт тусгуулсан байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв</p>

<u>Илэрсэн асуудал 4</u>	Сумын ОНХС-ын 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй 4 төсөл, арга хэмжээний 26,919.3 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг гаргуулалгүй гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө бага
<p>Бодит байдал: Сумын ОНХС-ийн 2025 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 4 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан ч гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдээс хууль, журмын дагуу шаардагдах гүйцэтгэлийн баталгааг гаргуулалгүйгээр ажлыг эхлүүлсэн зөрчил илэрсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Автомашины зам тавих 470.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр шалгарсан Эн би девелопмент ХХК-тай гэрээ байгуулахдаа үнийн дүнгийн 3 хувь болох 14.1 сая төгрөг, • Баянцогтын 2-р багт бэлчээрийн худаг барих 113.8 сая төгрөгийн гэрээ байгуулах гүйцэтгэгчээр шалгарсан Гранд Холдинг ХХК-тай гэрээ байгуулахдаа үнийн дүнгийн 3 хувь болох 3.4 сая төгрөг, • Рашаант тосгонд ахмадын байр шинээр барих 159.0 сая төгрөгийн гэрээ байгуулах гүйцэтгэгчээр шалгарсан Гранд Холдинг ХХК-тай гэрээ байгуулахдаа үнийн дүнгийн 3 хувь болох 4.8 сая төгрөг, • Рашаант тосгоны ЭМТ-ийн барилгын дотор халаалт, цэвэр усны шугамын засвар 154.5 сая төгрөгийн гэрээ байгуулах гүйцэтгэгчээр шалгарсан Есөн хэлхээ ХХК-тай гэрээ байгуулахдаа үнийн дүнгийн 3 хувь болох 4.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээний гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулсан байгууллагаар гаргуулаагүй байгаа нь тухайн байгууллагад гэрээний үүргээ биелүүлэх хөшүүрэг, хариуцлага үүрүүлэх нөхцөл боломж бүрдүүлээгүй байгаа холбогдох хууль тогтоомжийг зөрчиж байна. 	

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-ын 3.1 дэх "Хуулийн 42.1-д зааснаас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас багагүй үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчид хүргүүлнэ"

Асуудлын үндсэн шалтгаан:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй. Дотоод хяналт сул

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Тухайн байгууллага гэрээний үүргээ биелүүлэхгүй байх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдахгүй байх. Гэрээний үүргээ биелүүлээгүйгээс байгууллага хохирох.

Шийдвэр: 2026 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээний гэрээ байгуулах зөвшөөрөл авсан аж ахуйн нэгж байгууллагаар гүйцэтгэлийн баталгааг гаргуулан гэрээг байгуулах албан шаардлага хүргүүлэх.

<u>Илэрсэн асуудал 5</u>	Төсвийн орлогын бүрдүүлэлт 2025 оны эхний хагас жилийн байдлаар 13.3 хувь буюу 78,232.8 мянган төгрөгөөр тасарсан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал:	Эхний хагас жилийн байдлаар 588,249.0 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 510,016.2 мянган төгрөгийн буюу 86.7 хувийн биелэлттэй байна. Төлөвлөгөө нэр төрлөөр нь биелэлтийг тулган баталгаажуулахад үйл ажиллагааны орлого 40,623.9 мянган төгрөгөөр буюу 51.1 хувиар, бууны албан татвар 300.0 мянган төгрөгөөр буюу 50.0 хувиар, малд ногдуулах албан татвар 46,703.2 мянган төгрөгөөр буюу 28.7 хувиар, улсын тэмдэгтийн хураамж 634.8 мянган төгрөгөөр буюу 42.3 хувиар, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны хураамж 51,714.3 мянган төгрөгөөр буюу 100.0 хувиар, хог хаягдлын үйлчилгээний хураамж 1,417.8 мянган төгрөгөөр буюу 46.5 хувиар, ан амьтны нөөц ашигласны төлбөр 303.0 мянган төгрөгөөр буюу 100.0 хувиар, торгуулийн орлого 8,696.3 мянган төгрөгөөр буюу 82.4 хувиар, бусад орлого 3,998.8 мянган төгрөгөөр буюу 80.0 хувиар тус тус тасарсан байна.
Байх ёстой шаардлага /шалгуур/:	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"
Асуудлын үндсэн шалтгаан:	Төсвийн орлогын төлөвлөгөө тасрахад голлон нөлөөлсөн шалтгаан нь тус сумын татварын байцаагч хүүхэд асрах чөлөөтэй байгаа гэх үндэслэлээр орлогын төлөвлөгөөнүүд тасарсан.
Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:	Төсвийн орлого бүрэн төвлөрөөгүйгээс шалтгаалан төлөвлөгдсөн зардлуудын санхүүжилтийн эх үүсвэр тасрах. Төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмж буурах, Хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэхгүй байх
Шийдвэр:	Төсвийн орлогын бүрдүүлэлтийг ангилал тус бүрээр төлөвлөгөөний дагуу бүрэн төвлөрүүлэх, ТЕЗ-д төсвийн орлогыг бүрдүүлэхтэй холбоотой татварын байцаагчийг орон

нутагт томилон ажиллуулахад мэргэжлийн байгууллагатай нь хамтран дэмжлэг үзүүлэх чиглэлээр үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллах зөвлөмж хүргүүлэх.

<u>Илэрсэн асуудал 6</u>	ОНХС-аар санхүүжүүлэх чиг үүрэгт үл хамаарах 109,915.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 арга хэмжээг төлөвлөж батлуулсан.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
<p>Бодит байдал: Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2025 онд шинээр хэрэгжих 2,928,946.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 25 төсөл арга хэмжээнээс 109,915.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээ нь үйл ажиллагааны шинж чанартай байна. Үүнд:</p> <p>ОНХС-ийн хөрөнгөөр</p> <ul style="list-style-type: none"> • Золбин нохой устгах 6,000.0 мянган төгрөг • Үүрэн телефоны сүлжээтэй болох 103,915.0 мянган төгрөг <p>Энэ нь сумын төсвийн хөрөнгө оруулалтын чиг үүрэгт хамаарахгүй, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн байна.</p>	
<p>Байх ёстой шаардлага /шалгуур/:</p> <p>Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.4-д "Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт тухайн засаг захиргааны нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй.", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.5.1-4.5.12 заалтууд</p>	
<p>Асуудлын үндсэн шалтгаан:</p> <p>ОНХС-ийн хөрөнгөөр 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг журмын дагуу төлөвлөөгүй.</p>	
<p>Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:</p> <p>Төсвийн хөрөнгө оруулалтын шалгуур хангахгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээр төсвийн хөрөнгийн үр ашиг, үр нөлөө буурна.</p>	
<p>Шийдвэр:</p> <p>2026 оны төсвийг батлуулахдаа ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй төсөл, арга хэмжээг төсөвт тусгахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.</p>	

<u>Илэрсэн асуудал 7</u>	Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ариутгах татуургын шугам сүлжээ байгуулах талаар тусгаагүй энэ талаар арга хэмжээ аваагүй, бохир ус ил задгай урсаж орчны бохирдол үүсгэж иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлд сөрөг нөлөө үзүүлж байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
<p>Бодит байдал:</p> <p>Орхонтуул сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ариутгах татуургын шугам сүлжээ /цэвэрлэх байгууламж/ байгуулах талаар тусгаагүй, орон нутгийн удирдлагаас энэ талаар арга хэмжээ аваагүй нь усан хангамж, ариутгах татуургын инженерийн дэд бүтцийн шугам сүлжээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулаагүй байгаа нь хүн амын эрүүл, аюулгүй орчныг хангахгүй байна.</p>	

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн 11.1.1.хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үндэслэн төсөл санаачлах, боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, Хот, суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.Сумын Засаг дарга нь тухайн сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын баримт бичигтэй уялдуулан ус хангамж, ариутгах татуурга, инженерийн дэд бүтцийн шугам сүлжээг бүрдүүлж, ашиглалт, үйлчилгээг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна, Эрүүл ахуйн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.хүн амын эрүүл, аюулгүй орчныг хангах талаар асуудал боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх;

Асуудлын үндсэн шалтгаан:

Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон дэд бүтцийн асуудлыг тогтвортой бодлого, төлөвлөгөөгүй, мэргэжлийн байгууллагуудтай хамтын ажиллагаа хангалтгүй, уялдаа холбоогүйгээс шалтгаалсан

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Ус хангамж, ариутгах татуургын системгүй, **аюулгүй ажиллах нөхцөл бүрдээгүй**, цаашлаад орон нутгийн иргэдийн амьдрах орчны чанарт сөргөөр нөлөөлөх,

Шийдвэр:

Цаашид орчны бохирдлыг бууруулах, хүн амын эрүүл, аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор сумын нутаг дэвсгэрт цэвэрлэх байгууламж байгуулах асуудлыг аймаг, сумын төсвийн хөрөнгөөр шийдвэрлэх **зөвлөмж** хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 8</u>	Хөрөнгө оруулалтын 3,365,290.2 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 40 төсөл, арга хэмжээ хуулийн хугацаанд худалдан авах ажиллагааг бүрэн дуусгаагүй, үүнээс хэмнэлтэд тооцох 1,141,750.4 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний төлөвлөсөн хугацаа хэтэрсэн байхад гэрээ байгуулж зарцуулах шийдвэр гаргасан байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их
Бодит байдал: Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний бэлтгэн нийлүүлэгчийн сонгон шалгаруулалтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн дагуу tender.gov.mn цахим системд зарлан зохион байгуулсан боловч дараах төсөл, арга хэмжээнүүд хуулийн хугацаанд хэрэгжээгүй, зарим нь санхүүжилт зогссон, зарим нь бүр эхлээгүй байна. Үүнд: Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих: <ul style="list-style-type: none"> • Рашаант сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг 60,000.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг 2025.06.23-ны өдөр Эн би девелопмент ХХК-тай, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжих: <ul style="list-style-type: none"> • Ой хээрийн түймэр унтраах иж бүрэн багаж хэрэгсэл худалдан авах, Рашаант тосгонд “Сирень” дохио худалдан авах 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.06.27-ны өдөр Хар бүргэд бүлэг-тэй, • Рашаант тосгонд ахмадын байр шинээр барих 159,013.7 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.07.21-ний өдөр Баялаг тавиун уужим констракшн ХХК-тай, • Рашаант тосгоны ЕБС-ийн спорт заал засварлах 69,106.1 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.06.23-ны өдөр Баялаг тавиун уужим констракшн ХХК-тай, • Рашаант тосгонд үерийн далан байгуулах 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.06.17-ны өдөр Хадлангийн бүлгийн ахлагч-тай, • Автомашины зам тавих (Төмөр замын гарамнаас сургуулийн ар талаар буюу төв 	

<p>замын хажуугаар) 470,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.06.16-ны өдөр Эн Би Девелопмент ХХК-тай,</p> <ul style="list-style-type: none"> • Баянцогтын 2-р багийн ЕБС-ийн дотуур байрны хатуу эдлэл худалдан авах 40,100.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг Их Жээт ХХК-тай, • 1-р цэцэрлэгийн дээврийн борооны хаялага хийх 15,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.06.17-ны өдөр Бүтээлч бүлгийн ахлагч-тай, • Дэл, Туулын дэнж хорооллын ухаалаг худагуудад ус цэвэршүүлэгч худалдан авах 32,650.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.06.13-ны өдөр Ирмүүн Бармат ХХК-тай , • Хүүхэд хөгжлийн төвийн гадна тоглоомыг шинэчлэх 12,974.5 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.06.24-ний өдөр Цахиур бүлгийн ахлагч-тай, <p>Малын тоо толгойн албан татварын хөрөнгө оруулалтаар санхүүжих:</p> <ul style="list-style-type: none"> • Мал угаалгын ванн байгуулах 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.07.01-ний өдөр Нутгийн хишиг бүлэг-тэй, • Малын өвсний хашаа байгуулах 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.07.01-ний өдөр Нутгийн хишиг бүлэг-тэй, • Малын тарилга хийх зөөврийн хашаа худалдан авах 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.07.01-ний өдөр "Эвсэл" бүлэг-тэй, • Булгийн эх хашаажуулах 20,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг 2025.06.13-ны өдөр иргэн Даваадорж-той, • Золбин нохой устгалын зардал 1,232.0 мянган төгрөгийн арга хэмжээг 2025.06.24-ний өдөр Хамтарсан баг-тай тус тус гэрээ байгуулсан байна. Энэ нь Төсвийн болон Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн байна.
--

Байх ёстой шаардлага /шалгуур/:

Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-д "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.1.1-т "Батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах", 13.1.3-д "хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх", 13.1.4-д "төсөл, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд бүрэн хэрэгжих боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд гэрээ байгуулах шийдвэр гаргахгүй байх"

Асуудлын үндсэн шалтгаан:

Худалдан авах ажиллагааны төлөвлөлт хангалтгүй, зохион байгуулалтын уялдаа холбоо сул

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/:

Тухайн төсөл, арга хэмжээний үр ашиг буурах, санхүүжилт тодорхойгүй нөхцөл үүссэн

Шийдвэр:

Төсвийн болон Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн, худалдан авах ажиллагааг хугацаа хэтрүүлэн гэрээ байгуулах шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнуудад хариуцлага тооцох **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

<u>Илэрсэн асуудал 9</u>	Захиргааны акт гаргахдаа хууль зүйн үндэслэл болгон дурдсан хууль, тогтоомжийн нарийвчилсан зүйл, заалт нь тухайн актын агуулга, шийдвэрийн утгатай нийцэхгүй зөрчилтэй байна.
<u>Асуудлын ангилал</u>	Нөлөө их

Бодит байдал: Сумын Засаг даргын Захиргааны акт гаргасан хууль зүйн үндэслэл болгож дурдсан хууль, тогтоомжийн нарийвчилсан зүйл, заалт нь тухайн захирамжийн агуулга, шийдвэрийн утгатай нийцэхгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4-т заасан "Үр нөлөөтэй байх" болон 4.2.5-д заасан "Зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэлтэй байх" шаардлагыг хангахгүй байгаа юм. Үүнээс шалтгаалан захирамжийн хүчин төгөлдөр байдал, үр дүнд сөргөөр нөлөөлж байна.

Байх ёстой шаардлага /шалгуур/: Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4.-т "Үр нөлөөтэй байх", 4.2.5-д "Зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх"

Асуудлын үндсэн шалтгаан: Захиргааны акт боловсруулах, шийдвэр гаргах дотоод хяналт, нягтлан шалгах үйл явц сул, захиргааны хэм хэмжээний акт, холбогдох хууль тогтоомжийн зүйл, заалтыг судлах, ашиглах практик төлөвшөөгүй байна

Байгууллагад үзүүлэх нөлөө /үр дагавар/: Захиргааны ерөнхий хууль, захиргааны хэм хэмжээний акт зөрчигдөх

Шийдвэр:

Захиргааны актад ерөнхий зохицуулалтай хуулийн заалтыг үндэслэхдээ зөвхөн эрх олгосон заалтыг үндэслэж шийдвэр гаргаж байх зөвлөмж хүргүүлэх.

ДӨРӨВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын газраас Орхонтуул сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу дотоод аудитыг хийж гүйцэтгэхэд илэрсэн алдаа зөрчлийг үндэслэн **"Сайжруулах шаардлагатай"** гэсэн дүгнэлтийг өгч байна.

Байгууллага өөрийн зорилгодоо хүрэхийн тулд эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэн, дотоод хяналтыг үр нөлөөг сайжруулах тогтолцоог бий болгож шийдвэр гаргалтад түүнийг үр дүнтэй ашиглаж хэвших шаардлагатай байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь "давтамжтай буюу 1-р түвшин"-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 21-79% нь "нөлөө ихтэй" гэж үзсэн

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:
ДОТООД АУДИТОР

Г.ДОРЖДЭРЭМ

ТАЙЛАН ХЯНАСАН:
ДАРГА, СХШУАБ

Г.ОДСҮРЭН

ТАНИЛЦСАН:
ОРХОНТУУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА

Б.БОЛДБААТАР

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

С.ЭРДЭНЭЧИМЭГ

